

“ДАРХАН ГУРИЛ ТЭЖЭЭЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 03 сарын 17 өдөр

№ 02

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.2, 60.1, 60.2-д заалтууд, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 377 дугаар тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”, Төлөөлөн Удирдах зөвлөлийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Дархан Гурил Тэжээл” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 12 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Сөүлийн гудамж, Твин тауер 2/307 танхимд зарлан хуралдуулахаар тогтсугай.

2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлэхээр оруулсугай.

- i). Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай;
- ii). Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай;
- iii). Зохион байгуулалтын асуудал.
- iv). Бусад

3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2025 оны 04 дүгээр сарын 7 -ны өдрөөр тогтоосугай.

4. 2024 оны үр дүнгээр ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолын үндэслэлийн талаар Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд мэдээлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга (Ш.Энхтөр)-т үүрэг болгосугай.

5. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулах шийдвэр гарсантай холбогдуулан хувьцаа эзэмшигчдэд хурлын зарыг 2025 оны 03 дугаар сарын 22-ны өдөр Монголын хөрөнгийн биржийн цахим хуудас, компанийн өөрийн цахим хуудас, өдөр тутмын сонин, радио болон телевизийн аль нэгээр мэдээлсүгэй. Хурлын зар мэдээг анхны мэдээлсэн өдрөөс хойш 15 хоногийн дараа өдөр тутмын сонин болон радио, телевизийн аль нэгнээр анх мэдээлсэн хэлбэрийн дагуу дахин мэдээлэхийг хурал зохион байгуулах комисст даалгасугай.

6. Хувьцаа эзэмшигч нь энэхүү шийдвэрийн 1 дүгээр хавсралтад заасан бичиг баримтыг ажлын өдрүүдэд 09⁰⁰-17⁰⁰ цагийн хооронд Дархан уул аймаг, Дархан сум, 1-р баг, “Дархан Гурил Тэжээл” ХК -н өөрийн байранд ирж танилцаж болохыг дурдсугай.

7. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар материал, 1 дүгээр хавсралтад заасан баримт бичгийн бэлэн болгох эцсийн хугацааг 2025 оны 4 дүгээр сарын 10 -ны өдрөөр тогтсугай.

8. Тус компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс хэлэлцэх асуудлаар санал авах “Саналын хуудас”-ны агуулгыг 2 дугаар хавсралтаар баталсугай.

9. Хувьцаа эзэмшигчдээс санал авах хуудсыг хүлээн авах сүүлчийн өдрийг 2025 оны 4 дүгээр сарын 25 -ны өдрийн 12 цаг байхаар тогтсугай.

10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Ш.Энхтөр, хурал зохион байгуулах комиссын даргаар Б.Түвшинтөр-г томилсугай.

11. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын даргаар Д.Мөнхцэцэг, гишүүдээр Н.Ариунтунгалаг, С.Намсрайжав нарыг тус тус томилсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ш.ЭНХТӨР